

Ажлын хороодын ажиллах нийтлэг журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ажлын хороодыг байгуулж ажиллана.

1.2 Ажлын хороод нь дүүргийн бүхий л үйл ажиллагаатай холбоотой асуудлаар ИТХ-д дэмжлэг үзүүлэн ажиллана.

1.3 Ажлын хороодын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, хуралдааны дэгт нийцүүлэн явуулна.

Хоёр. Ажлын хороодын бүтэц, зохион байгуулалт

2.1 Ажлын хороодын бүрэлдэхүүнд хязгаар тогтоохгүй.

2.2 Ажлын хороон даргыг гишүүдийн олонхийн саналаар сонгож, төлөөлөгчдийн хуралдаанаар батална.

2.3 Ажлын хороодын гишүүд бусад ажлын хороонд орж ажиллах эрх нь нээлттэй байна.

2.4 Шаардлагатай тохиолдолд Тэргүүлэгчдийн шийдвэрээр ажлын хэсэг нэмж томилон ажиллуулж болно.

Гурав. Ажлын хорооны үйл ажиллагаа

3.1 Ажлын хороод нь өөрөө удирдах байгууллагын нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох учраас дүүргийн нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэд, өмчийн олон хэвшилт аж ахуйн нэгжийн ажилтан, төлөөлөгчдийг оролцуулж тэдний хүч туслалцаа, санаа бодлыг авах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

3.2 Ажлын хороо нь жилийн төлөвлөгөө гарган ажиллана.

3.3 Ажлын хороо нь хагас, бүтэн жилээр ажлын тайлангаа ИТХ-д тайлагнана.

3.4 Ажлын хороо нь гишүүдийн олонхийн саналд олонхийн саналд үндэслэн шийдвэр гаргана.

3.5 Ажлын хороон шийдвэр Тэргүүлэгчдийн хурлаар батлагдсанаар хүчин төгөлдөр болно.

Дөрөв. Ажлын хорооны хуралдаан

4.1 Ажлын хороодын үйл ажиллагааны үндсэн хэлбэр хурал байна.

4.2 Ажлын хороодын хурал нь ээлжит болон ээлжит бус байна.

4.3 Ээлжит хурлыг улиралд нэг удаа зарлан хуралдуулна.

4.4 Шаардлагатай гэж үзвэл гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

4.5 Ажлын хороодын гишүүдийн 50 хувиас дээш оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцож, олонхийн саналаар шийдвэр гаргана.